



ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2019 оны 9 сарын 19 өдөр

Дугаар 19/17

Улаанбаатар хот

Бүсэд түүхий нүүрсийг тусгай зориулалтаар ашиглах, түүхий нүүрс бүсээр дамжин өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 51 дүгээр захирамжийн 3 дугаар зүйл, Агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журам батлах тухай Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарын 2019 оны А/433-А/820 тоот хамтарсан тушаал/захирамжийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалт, Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2019 оны 19/04 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлд тус тус заасныг үндэслэн Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооноос ТОГТООХ нь:

1. Агаарын чанарыг сайжруулах бүсээр түүхий нүүрс нэвтрүүлж, тусгай зориулалтаар ашиглах асуудлыг хариуцан зохион байгуулж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Ажлын албанд даалгасугай.

2. Түүхий нүүрс тээвэрлэх битүүмжлэл бүхий тээврийн хэрэгсэл нь зам тээврийн яамнаас батлагдсан маршрутын дагуу Агаарын чанарыг сайжруулах бүсээр дамжин өнгөрөхийг зөвшөөрсүгэй. Дамжин өнгөрөх тээвэрлэлт хийж буй тээврийн хэрэгсэл нь бүсэд ачилт, буулгалтын ажиллагаа хийхийг хориглосугай.

3. Агаарын чанарыг сайжруулах бүсээр түүхий нүүрс дамжин өнгөрөх, тусгай зориулалтаар түүхий нүүрс ашиглаж буй эсэхэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч /С.Амарсайхан/, МХЕГ-ын дарга /Д.Цагаанхүү/, ЦЕГ-ын дарга /С.Баатаржав/ нарт тус тус даалгаж, харьяа байгууллагуудад чиглэл өгч ажиллахыг үүрэг болгосугай.

4. Уг тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орчны бохирдлыг бууруулах Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга /Ч.Гантулга/-д үүрэг болгосугай.

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН
САЙД, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Н.ЦЭРЭНБАТ